



131

МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/96

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, 84 дүгээр зүйлийн 84.4.1, 84.4.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, 50.2, 50.5, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Вагон түрээслэх" түрээслүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Д.Рэнцэнбямба	Захиргаа, удирдлагын газрын дарга
Нарийн бичиг:	Д.Төмөрчөдөр	Худалдан авалтын мэргэжилтэн
Гишүүд:	Г.Цолмонбаяр	Тээвэр, ложистикийн газрын дарга
	Б.Сүхчулуун	Инженер технологийн хэлтсийн дарга
	Г.Өлзийбаяр	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга
	С.Өлзийбүрэн	Худалдан авалтын хэлтсийн дарга
	Х.Нямсүрэн	Төлөвлөлтийн эдийн засагч
	Х.Энхбат	"Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл" ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн /зөвшилцсөнөөр/
	Н.Энхжаргал	"Нийслэл номч" ТББ-ын гишүүн /зөвшилцсөнөөр/

2. "Вагон түрээслэх" түрээслүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Д.Рэнцэнбямба/-нд даалгасугай.

3. Худалдан авах ажиллагаатай холбоотой баримт бичгийг архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг /Д.Төмөрчөдөр/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ОТГОНСҮХ

2024060931



132

МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/97

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, 84 дүгээр зүйлийн 84.4.1, 84.4.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, 50.2, 50.5, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "2ТЭ116 зүтгүүрийн 1 секц /бүрдэл/-д засвар, үйлчилгээ" хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Д.Рэнцэнбямба	Захиргаа, удирдлагын газрын дарга
Нарийн бичиг:	Д.Төмөрчөдөр	Худалдан авалтын мэргэжилтэн
Гишүүд:	Г.Цолмонбаяр	Тээвэр, ложистикийн газрын дарга
	С.Өлзийбүрэн	Худалдан авалтын хэлтсийн дарга
	Г.Өлзийбаяр	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга
	Б.Сүхчулуун	Инженер технологийн хэлтсийн дарга
	Б.Оргил	Зүтгүүрийн засвар хариуцсан инженер
	Х.Энхбат	"Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл" ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн /зөвшилцсөнөөр/
	Н.Энхжаргал	"Нийслэл номч" ТББ-ын гишүүн /зөвшилцсөнөөр/

2. "2ТЭ116 зүтгүүрийн 1 секц /бүрдэл/-д засвар, үйлчилгээ" хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Д.Рэнцэнбямба/-нд даалгасугай.

3. Худалдан авах ажиллагаатай холбоотой баримт бичгийг архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг /Д.Төмөрчөдөр/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ОТГОНСҮХ

2024060905



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/98

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, 84 дүгээр зүйлийн 84.4.1, 84.4.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, 50.2, 50.5, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "ES44ACi (Evolution)-2101 зүтгүүрт их засвар" хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Д.Рэнцэнбямба	Захиргаа, удирдлагын газрын дарга
Нарийн бичиг:	Б.Ундрах	Худалдан авалтын мэргэжилтэн
Гишүүд:	Г.Цолмонбаяр	Тээвэр, ложистикийн төлөвлөлтийн газрын дарга
	С.Өлзийбүрэн	Худалдан авалтын хэлтсийн дарга
	Г.Өлзийбаяр	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга
	Б.Сүхчулуун	Инженер технологийн хэлтсийн дарга
	Б.Оргил	Зүтгүүрийн засвар хариуцсан инженер
	Х.Энхбат	"Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл" ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн /зөвшилцсөнөөр/
	Н.Энхжаргал	"Нийслэл номч" ТББ-ын гишүүн /зөвшилцсөнөөр/

2. "ES44ACi (Evolution)-2101 зүтгүүрт их засвар" хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Д.Рэнцэнбямба/-нд даалгасугай.

3. Худалдан авах ажиллагаатай холбоотой баримт бичгийг архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг /Б.Ундрах/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ОТГОНСҮХ

2024000906



134

МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/99

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Төмөр замын тээврийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.2, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.11, Компанийн хөдөлмөрийн дотоод журмын 1 дүгээр зүйлийн 1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах журам"-ыг нэгдүгээр, "Үнэлгээний хуудасны загвар"-ыг хоёрдугаар, "Биет байдлын шалгалт өгөх ажил мэргэжлийн жагсаалт"-ыг гуравдугаар, "Сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн"-ийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг нийт ажилтанд танилцуулж, хэрэгжүүлж ажиллахыг зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлага, өртөөдийн дарга нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /Д.Рэнцэнбямба/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/80 дугаартай тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ОТГОНСҮХ

2024000956

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн
А/99 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралт



Хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ журмын зорилго нь “Монголын төмөр зам” ТӨХК /цаашид “Компани” гэх/-ийн сул, эзгүй орон тоог нөхөх, ажилтан сонгон шалгаруулах, мэдлэг ур чадварын нэгдсэн шалгалтыг зохион байгуулах зэргээр мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Хүний нөөцийг бүрдүүлэхэд энэхүү журам, Хөдөлмөрийн тухай хууль, Компанийн хөдөлмөрийн дотоод журам болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг дагаж мөрдөнө.

Хоёр. Зарчим

2.1 Компанийн хүний нөөцийг бүрдүүлэхдээ дараах зарчмыг баримтлана. Үүнд:

2.1.1 Ажил горилогчийг үндэс угсаа, арьс өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, шашин шүтлэг, үзэл бодол, намын ялгаа зэргээр нь ялгаварлан гадуурхахгүй байх,

2.1.2 Ажлын байранд тавигдаж буй шаардлагыг хангасан ажил горилогчдыг сонгон шалгаруулж, шалгаруулалтад тэнцсэн бол ажлын байраар хангах,

2.1.3 Мэдлэг, ур чадвар, ажлын туршлагыг харгалзан үзэх, үнэлэх, нээлттэй, ил тод байх,

Гурав. Хүний нөөцийг бүрдүүлэх үйл ажиллагаа

3.1. Компанийн сул, эзгүй орон тоог дараах аргаар нөхнө.

3.1.1. Нээлттэй сонгон шалгаруулах

3.1.2. Нөөцөөс нөхөх

3.1.3. Албан тушаал ахих хүсэлтэй ажилтныг сонгон шалгаруулалтад оролцуулах

3.1.4. Ажилтантай харилцан тохиролцсоны үндсэн дээр аж ахуйн нэгж, байгууллага дотроо, харьяа нэгж, салбарын хооронд ажилтныг гурван жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулах

3.1.5. Ажилтны төгссөн сургууль, ажлын туршлагад үндэслэн харилцан тохиролцох

3.2. Компанийн хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагыг үндэслэн ажилтан сонгон шалгаруулах саналаа ажлын байранд тавигдах шаардлагын хамт Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжид бичгээр ирүүлнэ.

Дөрөв. Сонгон шалгаруулах үйл ажиллагаа

4.1. Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж нь ажилтан сонгон шалгаруулахдаа энэ журмын 3.1.1, 3.1.3-т заасан хэлбэрийн аль нэгийг сонгож, Гүйцэтгэх захиралд танилцуулснаар сонгон шалгаруулалтын зарыг ажлын 5 хоногийн дотор компанийн цахим хуудсанд байршуулна.

4.2 Нээлттэй сонгон шалгаруулах зарын дагуу зарлагдсан ажлын байранд ажиллах хүсэлтэй иргэн дараах материалыг бүрдүүлнэ.

4.2.1. Компанийн анкетыг үнэн зөв бөглөх

4.2.2. Иргэний үнэмлэхний хуулбар эсхүл е-монголиа цахим хуудасны лавлагаа

4.2.3. Их, дээд сургууль, тусгай мэргэжлийн сургуулийн диплом, мэргэжлийн үнэмлэхний нотариатаар батлуулсан хуулбар

- 4.2.4. Нийгмийн даатгалын лавлагаа болон эрүүл мэндийн үзлэгийн хуудас
- 4.2.5. Урьд нь ажил эрхэлж байсан бол ажлаас чөлөөлөгдсөн тушаалын хуулбар
- 4.2.6. Ажлын байрны онцлогийг харгалзсан бусад материал

4.3. Сонгон шалгаруулалтыг бичиг баримт-ярилцлагын, сорилын болон биет байдлын гэсэн үе шатаар зохион байгуулна.

4.4. Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж ажил горилогчдоос ирүүлсэн бичиг баримтад урьдчилан үзлэг хийж, бүрдэл хангагдсан нөхцөлд шалгалтад оруулна.

4.5. Ажил горилогчоос ирүүлсэн холбогдох материалд авагдсан мэдээллийн хүрээнд бичиг баримт-ярилцлагын шалгалтыг авна.

4.6. Бичиг баримт-ярилцлагын шалгалт нийт 40 онооноос бүрдэх бөгөөд шалгалт авсан комиссын гишүүдийн дундаж үнэлгээгээр ажил горилогчийг үнэлнэ.

4.7. Сорилын шалгалтыг дараах шалгалт нийт 60 онооноос бүрдэх бөгөөд 60 асуултын хүрээнд цахим хэлбэрээр авна.

№	Шалгалтын асуултын төрөл	Шалгалтын асуултын хэмжээ		
		Хөдөлгөөнтэй шууд холбоотой		Хөдөлгөөнтэй шууд бус холбоотой
		Ашиглалтын чиглэл	Засварын чиглэл, бусад	
1	Үндсэн мэргэжлийн асуулт /тухайн ажлыг гүйцэтгэх технологийн горим карт г.м/	15	35	30
2	Төмөр замын тээврийн тухай хууль, Төмөр замын нийтлэг багц дүрэм, Төмөр замын техник ашиглалтын журам, Төмөр замын дохиолол холбооны журам, Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам г.м/	35	15	10 /төмөр замын ерөнхий курс ТЗЕК/
3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	5	5	10
4	Хууль эрх зүй, ажлын байрны тодорхойлолт, дүрэм, журам	5	5	10
	Нийт асуулт	60	60	60

4.8. Төмөр замын хөдөлгөөнтэй шууд холбоотой хавсралтад заасан нарийн мэргэжлийн ажлын байранд баримт бичиг-ярилцлага, сорилын шалгалтанд өндөр оноо авсан ажил горилогчоос биет байдлын шалгалтыг авна.

4.9. Шалгалтын дүнгээр 0-59 оноог "Хангалтгүй", 60-79 оноог "Хангалттай", 81-100 оноог "Бүрэн хангалттай" гэж үзнэ.

4.10. Дагалдан ажилтан, ажлын байр өөрчлөгдөж өөр ажлын байранд сэлгэн, шилжүүлэн ажиллуулахад тухайн ажлын байранд "Тэнцэх" эсэхийг тодорхойлох зорилгоор сорилын шалгалтыг авч, 40 ба түүнээс дээш сорилыг зөв бөглөсөн бол шалгалтанд тэнцсэнд тооцно.

4.11. Ажил олгогч ажилтныг ажилд авахдаа тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангах эсэхийг нь шалгах зорилгоор туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ байгуулах бөгөөд гэрээний хугацаа дуусахаас өмнө ажил горилогч нарын хамт шалгалтанд хамрагдах нөхцөлөөр хангана.

4.12. Шалгалтанд 61 ба түүнээс дээш оноо авсан ажил горилогчдыг онооны эрэмбээр жагсааж, нөөцөд бүртгэн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

4.13. Шалгалтад тэнцсэн ажил горилогчийг 1 жилийн хугацаанд нөөцөд бүртгэх бөгөөд сул орон тоо гарсан нөхцөлд онооны эрэмбийн дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулна.

4.14. Ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагад 1 жилийн дотор шалгалтад хамрагдсан ажил горилогчоос шалгалт авахгүйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.

4.15. Ажил горилогчийг төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцэж, нөөцөд бүртгэлтэй бол шалгалтад оролцуулахгүйгээр компанийн захиргааны чиглэлийн ажлын байранд хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллуулж болно.

4.16. Ажил горилогч нь улсын болон компанийн захиалга, тэтгэлэгээр суралцсан эсхүл Дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог "Times Higher Education World University Rankings" болон "Academic Ranking of World Universities" байгууллагын тогтоосон эрэмбээр эхний 100-д багтсан их, дээд сургуульд магистр, докторын зэрэг хамгаалсан бол давуу тал болох бөгөөд харилцан тохиролцож ажиллуулна.

4.17. Ажил горилогч мэргэжлээрээ 6-аас доошгүй жил ажилласан дадлага туршлагатай бол харилцан тохиролцон ажиллуулж болно.

4.18. Сул, эзгүй орон тоонд өрсөлдөж албан тушаал ахих хүсэлт гаргасан үндсэн ажилтанд шалгалтад авсан оноо дээр 10 оноог нэмж олгоно. Энэхүү заалт шалгалтад хамрагдаж буй туршилтаар ажилласан ажилтанд хамаарахгүй.

Тав. Сонгон шалгаруулах ажлын хэсэг

5.1. Гүйцэтгэх захирлын тушаалаар сонгон шалгаруулах үйл ажиллагаа хариуцсан ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна. Мэдлэг ур чадварын нэгдсэн шалгалтыг өргөтгөсөн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж болно.

5.2. Ажлын хэсэг нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

5.3. Ажлын хэсэг ажилтан сонгон шалгаруулах саналын дагуу сорилын шалгалтын материалыг урьдчилан бэлтгэнэ. Шалгалтын материалыг бэлтгэхэд тухайн ажлын байрны чиглэлийн ажилтан, хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын төлөөллийг татан оролцуулж болно.

5.4. Ажлын хэсэг хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжээс ажилтан сонгон шалгаруулах материал хүлээн авах хугацаа дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор шалгалтыг зохион байгуулж, дүнг Гүйцэтгэх захиралд танилцуулна.

5.5. Төмөр замын хөдөлгөөнтэй шууд холбоотой хавсралтад заасан нарийн мэргэжлийн ажлын байранд нөөцөөс нөхөх тохиолдолд биет байдлын шалгалтыг авна.

5.6. Биет байдлын шалгалтыг ажлын хэсгийн саналыг үндэслэн хавсралтад заагдаагүй нэгж, ажилтнаар гүйцэтгүүлж болно.

5.7. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хурлын тэмдэглэлийг тухай бүр хөтлөх ба ажлын хэсэг иргэдийн шалгалтын дүнг хэлэлцэж, шалгаруулалтын явц, үр дүнг иргэдэд ил тод нээлттэй мэдээлнэ.

5.8. Шалгалтад оролцож, хангалтгүй үнэлгээ авсан ажилтанд мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх 30-аас доошгүй хоногийн хугацаа олгож, энэ хугацаанд шалгалтад оролцуулахгүй.

Зургаа. Мэдлэг ур чадварын нэгдсэн шалгалт

6.1. Ажилтнуудаас мэдлэг ур чадварын нэгдсэн шалгалтыг 2 жил тутам 1-ээс доошгүй удаа зохион байгуулж авна.

6.2. Нэгдсэн шалгалттай жилийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор нэгдсэн шалгалтад хамрагдах ажил, мэргэжлийн жагсаалтыг баталж, ажилтнуудад мэдээлэх бөгөөд шалгалтад бэлтгэх хүрээнд ажилтнуудад мэдлэг олгох сургалтыг ажил олгогч зохион байгуулна.

6.3. Шалгалтыг урьдчилан бэлтгэсэн 100 хүртэлх сорилын тестээр авах бөгөөд жагсаалтад тусгагдсан ажлын байранд биет байдлын шалгалтыг авна.

6.4. Шалгалтад хангалтгүй үнэлгээ авсан ажилтнуудад мэдлэгийн түвшин, ур чадвараа дээшлүүлэх хугацаа олгох бөгөөд 30-аас доошгүй хоногийн хугацааны дараа давтан шалгалт авна.

6.5. Давтан шалгалтад хангалтгүй үнэлгээ авсан ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ажил олгогчийн санаачлагаар цуцлана.

Долоо. Гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх

7.1. Шалгалттай холбоотой гомдлоо шалгуулагч нь шаардлага, үндэслэлийг тодорхой дурдаж, холбогдох баримтын хамт бичгээр Гүйцэтгэх захиралд гаргаж, шийдвэрлүүлнэ.

7.2. Гүйцэтгэх захирал гомдол үндэслэлтэй гэж үзвэл оролцогчийг дахин шалгалтад оролцуулах асуудлыг ажлын 3 хоногт багтаан шийдвэрлэнэ.

Найм. Бусад

8.1. Ажлын хэсэг эсхүл ажилтан сонгон шалгаруулах шалгалтын материалын нууцыг бусдад задруулсан, шан харамж авсан бол хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.2. Хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, бусдад дарамт шахалт үзүүлэхийг хориглоно.

8.3. Шалгалтад оролцогч шалгалтын хариултыг бусдад дамжуулсан, завдсан, бусдад саад учруулсан бол шалгалтаас гаргаж, "Хангалтгүй" үнэлгээ авсанд тооцно.

8.4. Нөөцөд бүртгэгдсэн иргэд болон хүсэлт гаргасан ажилтнуудын нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэхийг Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж, шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах асуудлыг мэдээлэл, технологийн асуудал хариуцсан нэгж хариуцан ажиллана.

---oOo---

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн
А/99 дугаар тушаалын Хоёрдугаар хавсралт



Үнэлгээний хуудас

№	Сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр	Ерөнхий шаардлагын үнэлгээ /35 оноо/				Мэдлэг, ур чадварын түвшингийн үнэлгээ /45 оноо/	Биет байдлын шалгалт /Тэнцэх эсэх/	Нийт оноо	Нийт оноогоор эзлэх байр
		Боловсрол	Туршлага	Мэргэшсэн байдал	Ярилцлага				
	Өгвөл зохих оноо	10	10	10	10	60	Шалгалт авсан гишүүдийн олонхийн саналаар	100	
A	1	2	3	4	5	6	7	8	9
1									
2									

Сонгон шалгаруулах ажлын хэсэг


Дарга:

Нарийн бичгийн дарга:.....

Гишүүд:.....

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2024 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн
А/99 дугаар тушаалын Гуравдугаар хавсралт

Биет байдлын шалгалтад хамрагдах ажил,
мэргэжлийн жагсаалт



№	Нэршил
1	Өртөөний жижүүр
2	Зөрлөгийн дарга
3	Зөрлөгийн жижүүр
4	Өртөөний туслах жижүүр
5	Галт тэрэгний найруулагч
6	Галт тэрэгний туслах найруулагч
7	Тооцооны оператор
8	Ачаа вагон хүлээлцэгч /хүлээн авах пүүлэгч/
9	Пүүний оператор
10	Засварын хүлээн авагч
11	Засварын мастер
12	Зааварлагч машинч
13	Дохиоллын механикч
14	Дохиоллын монтёр
15	Холбооны механикч
16	Холбооны монтёр
17	Замын бригад
18	Замчин
19	Замын машин механизмын машинч

---oOo---

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн
А/99... дугаар тушаалын Дөрөвдүгээр хавсралт



**Сонгон шалгаруулах ажлын
хэсгийн бүрэлдэхүүн**

- **Ажлын хэсгийн дарга** Захиргаа, удирдлагын газрын дарга
- **Нарийн бичгийн дарга** Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга
- **Гишүүд** Чиглэл хариуцсан хяналтын байцаагч
Үүрэг даалгаврын биелэлт, тайлан
хариуцсан мэргэжилтэн

- Биет байдлын шалгалт авах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

№	Чиглэл	Цогтцэций өртөөнд	Төмөртэй өртөөнд
1	Хөдөлгөөн зохион байгуулалт	Өртөөн дарга	Өртөөн дарга
		Хөдөлгөөн хариуцсан орлогч дарга	Орлогч дарга
		ХАБЭА-н инженер	ХАБЭА-н инженер
2	Ачаа тээвэр	Өртөөн дарга	Өртөөн дарга
		Ачаа тээвэр хариуцсан орлогч дарга	Орлогч дарга
		ХАБЭА-н инженер	ХАБЭА-н инженер
3	Дохиолол холбоо	Дохиолол холбооны ангийн дарга	Цогтцэций өртөөний бүрэлдэхүүн
		Дохиолол холбооны ахлах инженер	
		Холбооны инженер	
4	Замын анги	Замын ангийн дарга	Цогтцэций өртөөний бүрэлдэхүүн
		Замын ангийн ахлах инженер	
		Замын мастер	
5	Зүтгүүр	Зааварлагч машинч	Цогтцэций өртөөний бүрэлдэхүүн
		Хүлээн авагч	
		Ахлах инженер	